

ТЕСТ ДАМЖЛАГЫН МАШИНЧ IV ЗЭРЭГ

1. Шалнаас ... хэдэн метрээс дээш өндөрт байрласан тоноглолын эд ангиудад үйлчилгээ хийхдээ хаалт хашилт бүхий зөөврийн шат тавцан ашиглах ёстой вэ?

- А. 2 м-ээс дээш
- Б. 2,5 м-ээс дээш
- В. 1,5 м-ээс дээш
- Г. 1,3 м-ээс дээш

2. Эргэлдэж байгаа голын ил хэсэг нь тал талдаа ... хэдэн мм-ээс ихгүй байхаар бодож хагас муфьтэн хамгаалалт хийх ёстой вэ?

- А. 15 мм-ээс ихгүй
- Б. 10 мм-ээс ихгүй
- В. 12 мм-ээс ихгүй
- Г. 20 мм-ээс ихгүй

3. Аврах олсыг нэг удаа татах нь юу гэсэн утгатай вэ?

- А. Олсыг сулруул
- Б. Хэвийн байна
- В. Олсыг татаарай
- Г. Аюулгүй

4. Тоноглолын засварын ажил гүйцэтгэхэд аюулгүй ажиллагааг хангах зохион байгуулалтын хэдэн арга хэмжээ байдаг вэ?

- А. 6 арга хэмжээ
- Б. 3 арга хэмжээ
- В. 5 арга хэмжээ
- Г. 4 арга хэмжээ

5. Галын аюул бүхий ажил хийгдсэн нарядуудыг хадгалах хугацаа нь наряд олгогдсон өдрөөс эхлэн хэдий хугацаанд хадгалах вэ?

- А. 30 хоног
- Б. 6 сар
- В. 1 жил
- Г. 185 хоног

6. Нарядыг хэдэн удаа сунгаж болох вэ?

- А. Нарядыг сунгадаггүй.
- Б. 2 удаа
- В. 1 удаа
- Г. 3 удаа

7. Үйлдвэрийн хүчтэй шуугиантай нөхцөлд ажиллах шуугианы түвшингийн хэмжээ 10 дБ хүртэл байвал ажилтныг хэдий хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулах вэ?

- А. 6 сард
- Б. 12 сард
- В. 24 сард
- Г. 36 сард

8. Өндөрийн бүсийг хэдий хугацаанд хэдэн кг ачаагаар туршиж баталгаажуулах ёстой вэ?

- А. Жилд нэг удаа 225 кг
- Б. 24 сард 1 удаа 225 кг
- В. Сард нэг удаа 225 кг
- Г. 6 сард 1 удаа 225кг

9. Орчны агаарын халуун +25°C байхад дулааны хучилтын гадаргуу дээрх халуун хэдэн °C-ээс хэтрэх ёсгүй вэ?

- А. 45°C
- Б. 33°C
- В. 40°C
- Г. 25°C

10. Цахилгаан дулааны станцын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн суурийн суултанд ашиглалтад орсон анхны жилд хэдэн удаа ажиглалт хийх вэ?

- А. Улиралд 1 удаа
- Б. Жилд 2 удаа
- В. 3 удаа
- Г. 4 удаа

11. Наалдамхай болон өөрөө шатах идэвхижил ихтэй түүхий нүүрсний бункеруудыг хэд хоногт зөвшөөрөгдөх доод хэмжээнд нь хүртэл түвшинг нь багасгаж байх хэрэгтэй вэ?

- А. 7 хоногт 1-ээс доошгүй удаа
- Б. 15 хоногт 1-ээс доошгүй удаа
- В. Сард 1-ээс доошгүй удаа
- Г. 10 хоногт 1-ээс доошгүй удаа

12. Цахилгаан станц, цахилгаан ба дулааны шугам сүлжээний дунд ба их засвараас гарч байгаа тоног төхөөрөмжийг хэдэн цаг ачаалалтайгаар ажиллуулж, хүлээлгэн өгөх ба авах туршилт хийдэг вэ?

- А. 24-48 цаг
- Б. 24-72 цаг
- В. 48-72 цаг
- Г. 36-48 цаг

13. Техник ашиглалтын дүрэм, зааврууд, албан заавар /ажлын байрны тодорхойлолт/-ын ээлжит шалгалтыг ИТА, удирдах ажилтнуудаас хэдий хугацаанд авах вэ?

- А. Жилд 1 удаа
- Б. 2 жилд 1 удаа
- В. 3 жилд 1 удаа
- Г. 12 сард 1 удаа

14. Богино холбоотой ротор бүхий хөдөлгүүрийг хүйтэн байдлаас хэдэн удаа давтан залгахыг зөвшөөрөх вэ?

- А. 1 удаа
- Б. 2 дахин
- В. Давтан залгахыг хориглоно.
- Г. 3 дахин

15. Аваарийн троссын ямар үед татах вэ?

- А. Тонголлол эвдэрсэн үед
- Б. Хүн бэртэхээр хэмжээний гэмтэл гарсан үед
- В. Дээрх бүх тохиолдолд

16. Насанд хүрээгүй хүмүүсийг ямар ажил хийлгэхийг хориглох вэ?

- А. Ачаа зөөх
- Б. Хэмжүүр автомастикийн үйлчилгээ
- В. Зам талбай цэвэрлэх

17. Төмөр шатыг барих үед түүнээс хэдэн метрээс бага зайд байгаа цахилгаан дамжуулах шугамын гүйдлийг таслах, газардуулах, утасны гадуур бүрхүүл хийх, буулгаж зайлуулах вэ?

- А. 4м
- Б. 5м
- В. 6м

18. Түлэгдэх үед арьс цэврүүтэхийг хэддүгээр зэргийн түлэгдэлтэнд хамруулах вэ?

- А. 1-р зэрэг
- Б. 2-р зэрэг
- В. 3-р зэрэг

19. Наряд олгох эрх бүхий хүмүүсийн нэрсийн жагсаалтыг ямар хугацаанд шинэчилсэн гаргаж хэн батлах вэ?

- А. 6 сар тутамд үйлдвэрийн ерөнхий инженер батлаж жагсаалтын хуулбарыг ээлжийн дарга, ДИС-н өрөөнд тавина.
- Б. 12-р сард цехийн дарга баталж хуулбарыг ДИС-н өрөөнд тавина.
- В. Жил бүр үйлдвэрийн ерөнхий инженер батлаж жагсаалтын хуулбарыг ээлжийн дарга, ДИС-н өрөөнд тавина.

20. Ажлын байрны ойр тосолгооны материалыг тосолгооны саванд хадгалахыг зөвшөөрөх үү?

- А. Зөвшөөрнө
- Б. Зөвшөөрөхгүй

В. Ажлын байран дээрээ хадгална

21. Бункер дотор хүн ажиллаж байгаа тохиолдолд хэдэн ажиглагч томилох вэ?

- А. 1 ажиглагч
- Б. 2-с доошгүй
- В. 3 ажиглагч

22. Түлш өгөлтийг даруй зогсоож, таслах сойлтон хаалтыг хаах буюу тэжээгчийг зогсоох нь ямар үед авдаг арга хэмжээ вэ?

- А. Тоноглол залгах үед
- Б. Хүн бункерт унасан үед
- В. Цахилгааны гэмтэл

23. Туузан дамжлагын тормозны төхөөрөмж ямар үүрэгтэй вэ?

- А. Туузыг зогсоох үүрэгтэй
- Б. Туузыг эсрэг ухрахаас хамгаалах үүрэгтэй
- В. Туузын уян хатан байдлыг тохируулах үүрэгтэй

24. Суганы хонхор мөрнөөс цус алдвал анхны тусламжийг хэрхэн үзүүлэх вэ?

- А. Эгэмний артерийн судсыг эгэмний доод хонхорын ясанд шахаж дарна
- Б. Цусыг тогтоож боолт хийнэ
- В. Цээж, мөрөнд марелиар битүү боолт хийж эмнэлэгт хүргэх

25. А ангиллын гал түймэр нь ямар бодис, материалын гал түймэр вэ?

- А. Шингэн бодис, материалын
- Б. Хатуу бодис, материалын
- В. Хийн төлөв байдалтай бодис, материалын

26. Бункерт нүүрс цогшиж утаа гарч байгаа тохиолдолд бункер лүү орж болох уу?

- А. Гал унтарч байгаа болохоор боломжтой
- Б. Хориглоно
- В. 5-10 мин дараа орж болно

27. Хэдэн метрээс өндөр шатыг акт бүрдүүлж, комисоор хүлээн авсны дараа ашиглахыг зөвшөөрдөг вэ?

- А. 3 м
- Б. 4 м
- В. 5 м

28. Хөлдсөн шугам хоолойг ил галаар гэсгээхийг зөвшөөрөх үү?

- А. Зөвшөөрнө
- Б. Зөвшөөрөхгүй

29. Аль нь тусгай ажлын ангилалд орох вэ?

- 1. Өндөрт ажиллах
- 2. Оосорлогч дохиочин
- 3. Металл боловсруулах болон суурь машин дээр ажиллах
- 4. Мөнгөн устай ажиллах
- 5. Нөөцлөх сав болон худагт ажиллах

А. 1,2,3 Б. 1,3,4,5 В. 1,3,4 Г. Бүгд

30. Аваарийн троссыг татахад хэдий хугацаанд тоноглолууд бүрэн зогсох сөтой вэ?

- А. 5-10 секундын дараа
- Б. 15-30 секундын дараа
- В. Тросс татсан даруйд

31. Үйлчилж байгаа хүн хүрэхээс сэргийлж дамжлагын хөдөлгөөнтэй хэсгүүдэд юу хийх ёстой байдаг вэ?

- А. Хаалт хашилт

- Б. Анхааруулах тэмдэглэгээ
- В. Сауулах плакат

32. Нарядын хүчин төгөлдөр хугацааг хэн тогтоох вэ?

- А. Наряд олгогч тогтоох бөгөөд засварын графикийн батлагдсан хугацаанаас хэтрэх ёсгүй
- Б. Тоноглолын засварын графикт багтааж цехийн дарга тогтооно
- В. Наряд олгох эрх бүхий хүн тогтооно

33. 16-18 хүртэл насны эрэгтэй хүн 1 дугуйт тэргэнцэрээр хэдэн кг ачаа зөөхийг зөвшөөрөх вэ?

- А. 49кг
- Б. 55кг
- В. 60кг

34. Хүзүүний нугалам гэмтсэн байх эрсдэлтэй тохиолдолд амьсгалын замыг ямар аргаар чөлөөлөх вэ?

- А. Толгойг гэдийлгэн байрлуулж,эрүүний шонтогоос өргөх
- Б. Эрүүний өнцгөөс түлхэж амыг эрхий хуруугаар дарж ангайлгах
- В. Дээрхи хоёр ара хоёулаа зөв
- Г. Дээрхи хоёр арга хоёулаа буруу

35. Шаталт гэж юуг хэлэх вэ?

- А. Ихээхэн гэрэл, дулаан ялгаруулан хоромхон зуур явагддаг химийн исэлдэх урвал
- Б. Хүний эрүүл мэндэд аюултай хий үүсгэдэг процесс
- В. Дулаан ялгаруулдаг гинжин урвал

36. Түлш дамжлагын механизмуудыг ажилд залгахын өмнө яаж урьдчилан анхааруулсан үргэлжилсэн дохио өгөх вэ?

- А. Аваарийн сигнал дарах
- Б. Дуут дохио өгөх
- В. Чанга яригчаар зарлах

37. Төмөр баригч цахилгаан соронзонг гараар цэвэрлэхдээ юу анхаарах хэрэгтэй вэ?

- А. Туузан дамжлагыг зогсоосоны дараа заавал бээлий бээлийтэй ажиллах
- Б. Төмөр баригчийн хүчдэлийг тасалсны дараа заавал бээлийтэй ажиллах
- В. Туузан дамжлагыг зогсоож, төмөр баригчийн хүчдэлийг тасалсны дараа заавал бээлийтэй ажиллах

38. Туузан дамжлага дээгүүр гарахдаа юугаар гарах вэ?

- А. Дамжлагын доогуур шургаж гарах
- Б. Гарцын шатаар гарах
- В. Тойрч гарах

39. Наряд ам шийдвэрийн дууссан журналыг ямар хугацаанд хадгалах вэ?

- А. Сүүлийн бүртгэл хийснээс хойш 3 сар
- Б. Сүүлийн бүртгэл хийснээс хойш 6 сар
- В. Сүүлийн бүртгэл хийснээс хойш 12 сар

40. Цус тогтоох түр зуурын ямар аргууд байдаг вэ?

- А. Чангалуур тавих
- Б. Тусгай цэг дээр ясанд тултал дарах
- В. Үеэр нь нугалж боох
- Г. Даралттай боолт хийх
- Д. Бүгд зөв

41. Галын аюулгүй байдлыг хангах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нь хэний үүрэг вэ?

- А. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн үүрэг
- Б. Гал сөнөөгч-аврагч нарын үүрэг
- В. Хүн болгоны үүрэг

42. Шийдвэрээр ажил гүйцэтгэх үед хариуцлагатай удирдагч томилох уу?

- А. Томилох эсэхийг наряд, шийдвэр олгогч шийдвэрлэнэ
- Б. Томилно
- В. Томилохгүй ажлын шаардлагаас болж цехийн дарга шийдвэрлэнэ

43. Нүүрсийг буталсны дараа ширхэгийн хэмжээ хэдэн мм-с ихгүй байх ёстой вэ?
- А. 20мм
 - Б. 10мм
 - В. 15мм
 - Г. 25мм
44. Насанд хүрээгүй хүмүүсийг хлоржуулах тоноглолын үйлчилгээ хийх ажлыг хийлгэж болох уу?
- А. Зөвшөөрнө
 - Б. Зөвшөөрөхгүй
 - В. Зөвхөн хлоржуулаагүй үед
45. Бутлагчаас гарах нүүрсний хэмжээг ажиллагааны үед яаж тохируулах вэ?
- А. Хуягт хавтангийн налуугийн хэмжээг өөрчлөх
 - Б. Хөдөлгөөнтэй ба хөдөлгөөнгүй рещётканы нүхийг өөрчлөх
 - В. Хуягт брусс алх хоёрын хоорондын зайг тохируулах
 - Г. Роторын хэмжээг ойртуулж шахах
46. Түлшний дулаан гаргах чадвар гэж юу вэ?
- А. 1 кг хатуу буюу шингэн түлшийг бүрэн шатаахад ялгарах дулаан
 - Б. 1 кг хатуу түлшийг бүрэн шатаахад ялгарах дулаан
 - В. 1 кг хатуу буюу шингэн түлшийг бүрэн шатаахад ялгарах энерги
47. Туузан дамжлагын татах станц буюу тууз чангалагч ямар үүрэгтэй вэ?
- А. Ажиллагааны явцад туузын уян хатан байдлыг тохируулах
 - Б. Ажиллагааны явцад туузыг хазайхаас сэргийлэх
 - В. Хөтлөгч булны эргэлтийг хөтлөгдөгч буланд шилжүүлэх
48. Зөөврийн цахилгаан гэрэлтүүлэг нь хэдэн В-с хэтрэхгүй байх ёстой вэ?
- А. 36 В
 - Б. 220 В
 - В. 12 В
49. Наряд гэж юу вэ?
- А. Ажлын аюулгүй гүйцэтгэх байр, цаг хугацаа нөхцөл, аюулгүйн арга хэмжээнүүд болон бригадын бүрэлдэхүүн, ажлын аюулгүй гүйцэтгэх хариуцлагатнуудыг тодорхойлсон бичгэн шийдвэр юм
 - Б. Ажлыг аюулгүй гүйцэтгэх байр, аюулгүй байх нөхцөл, бригадын хүний тоо, нарядыг хариуцагч хүнийг тодорхойлох бичгэн шийдвэр
 - В. Ажлыг аюулгүй гүйцэтгэх бүх нөхцлийг хугацаатай заасан ба ажил гүйцэтгэх бүрэлдэхүүн, ахлагчийг тодорхойлох бичгэн шийдвэр
50. Тусламж үзүүлэгч бүх насны өвчтөнүүдэд амилуулах суурь тусламжийг хийхдээ цээж шахах, амьсгалуулах үйлдлийн хоорондын харьцаа хэд байх вэ?
- А. 5 шахалт даралт 1 амьсгалуулалт
 - Б. 30 шахалт 2 амьсгалуулалт
 - В. 10 шахалт 2 амьсгалуулалт
 - Г. 15 шахалт 1 амьсгалуулалт
51. Шатдаг бодис, материал гэж юу вэ?
- А. Галын эх үүсвэрийг ойртуулахад дөллөж асдаг бодис, материал
 - Б. Ердийн нөхцөлд галын эх үүсвэрийг ойртуулахад асаж, холдуулахад унтарч шатдаггүй бодис, материал
 - В. Ердийн нөхцөлд галын эх үүсвэрийг ойртуулахад асаж, холдуулахад өөрөө бие даан шатах чадвартай бодис, материал
52. Гэмтлийн дараах шинж тэмдэг илэрчээ. Аль тохиолдолд сээр нурууны гэмтэл вэ?
- А. Мөр хөдөлгөхөд өвдөх
 - Б. Амьсгалахад хүнд их өвдөлттэй байх
 - В. Бөхийж тонгойж болохгүй байх
53. Хүйтний улиралд туузан дамжлагын байранд хэдэн °С-с дээш хэмтэй байх ёстой вэ?
- А. 10°С

- Б. 5°C
- В. 15°C

53. Бутлагчын роторын эргэлт зогссоноос хойш 15-20 минутын дараа түүний нээлхийг онгойлгохыг зөвшөөрдөг. Энэ ямар учиртай вэ?

- А. Тэсрэлтээс хамгаалах
- Б. Их жинтэй тоноглол усраас удаан зогсдог
- В. Ашиглалтын зааварт хугацаа заагаагүй
- Г. Тоосролтыг эхүүл ахуйн нормт хэмжээнд байлгах

54. Хэдэн хэмээс дээш халуун агаартай хэсэгт засварын ажлыг хийх үед зөөврийн агаарын салхилуурын төхөөрөмжийг ашиглах вэ?

- А. 30°C
- Б. 33°C
- В. 25°C

55. Насанд хүрсэн эмэгтэйчүүд 2 дугуйтай түрдэг тэргэнцэрээр явах зам нь тэгш, налуу нь 0,02м-с ихгүй үед өргөх зөөх ачааны хүндийн дээд хэмжээ хэд байх вэ?

- А. 108 кг
- Б. 115 кг
- В. 125 кг

56. Залуурт ролик бусад роликоос ямар ялгаатай вэ?

- А. Туузны хазайлтыг тохируулах, бусад роликоос 1-2см нам
- Б. Туузны хазайлтыг тохируулах, бусад роликоос 1-2см өндөр
- В. Туузны хазайлтыг тохируулах, бусад роликоос 2-3см өндөр

57. Дамжлагын тууз ямар үүрэгтэй вэ?

- А. Хөтлөгч барабаны эргэлтийг хөтлөгдөгч барабанд дамжуулах
- Б. Нүүрсийг нэг дамжлагаас нөгөөд шилжүүлэх
- В. Ажлын ба ажлын бус роликуудыг эргэлтэнд оруулах
- Г. а, б

58. Орчны агаарын халуун 25°C байхад дулааны хучлагын гадаргуу дэрх халуун хэдэн градусихгүй байх байх вэ?

- А. 35°C
- Б. 40°C
- В. 45°C

59. 1000 В хүртэл хүчдэлтэй дамжуулах утас, гүйдэл дамжуулах хэсгээс нэрвэгдэгчийг чөлөөлөхийн тулд ямар материал зүйлсийг ашиглах вэ?

- А. Цахилгаан гүйдэл дамжуулахгүй материал
- Б. Хувцаснаас татаж салгана
- В. Олс, саваа, банз буюу гүйдэл дамжуулахгүй зүйлс ба хуурай зүйлс ашиглана

60. Буух хоолойг бөглөсөн нүүрсийг сэтгэж гаргахдаа юу хийх вэ?

- А. Нүүрс өгч байгаа туузан дамжлагыг зогсоож буух хоолойны сэтгэх нүхээр, тавцан дээр зогсож гүйцэтгэнэ
- Б. Нүүрс хүлээн авч байгаа туузан дамжлагыг зогсоож буух хоолойны сэтгэх нүхээр, тавцан дээр зогсож гүйцэтгэнэ
- В. Нүүрс өгч байгаа болон хүлээн авч байгаа туузан дамжлагуудыг зогссоны дараа буух хоолойны сэтгэх нүхээр, тавцан дээр зогсож гүйцэтгэнэ

61. Хөлдөж дагширсан нүүрсний мөргөцийг нураах, нүүрс буух хоолойн бөглөөсийг гаргах үед бункер дотор ажиллахыг зөвшөөрөх үү?

- А. Хориглоно
- Б. Хориглохгүй
- В. Зөвшөөрнө

62. Дүүжин ба зөөврийн шатыг өргөх буулгахад хэрэглэж байгаа суурин дээр бэхлэх боломжгүй үед ажлын даацаас хэд дахин их ачаагаар даруулж тогтвортой байдлыг хангах вэ?

- А. 1.25 дахин
- Б. 1.5 дахин

В. 2 дахин

63. Ажлын байран дахь галын аюулгүй байдлыг аль албан тушаалтан нар хариуцах вэ?
А. Галын аюулгүй байдлыг хариуцсан ажилтан хариуцана
Б. Тухайн ажлын байранд ажилладаг ажилтан хариуцана
В. Галын сайн дурын бүлгэмийн ахлагч хариуцана
64. Түлэгдэлтээс болж ухаан нь балартаж гүй хүндрэлд орсон хүнд анхан шатны тусламж хэрхэн үзүүлэх вэ?
А. 15-20 дусал валерины уусмал уулгах
Б. 20-25 дусал валерины уусмал уулгах
В. Этилийн спирт үнэрлүүлэх
65. Туузан дамжлагад засвар, тосолгоо, цэвэрлэгээ үйлчилгээ хийх, туузны хий эргэлтийг арилгахын өмнө дамжлагыг зогсоож, цахилгаан схемийг задлан удирдлагын түлхүүр дээр ямар аюулгүйн тэмдэг өлгөдөг вэ?
А. Бүү залга. Хүмүүс ажиллаж байна.
Б. Засвартай
В. Хүчдэлтэй
66. Бункерт наалдсан түлшийг хэрхэн цэвэрлэх вэ?
А. Хүн дотор орж цэвэрлэнэ
Б. Гараар тусгай зориулалтын жадаар сэтгэж
В. Механик арга ба гараар тусгай зориулалтын жадаар сэтгэж
67. Ажлын байр ихээхэн чийг, тоостой, газардуулгын металл гадаргатай шүргэлцэж болох онцгой нөхцөлд зөөврийн гэрэлтүүлэг хэдэн В-оос ихгүй хүчдэлээр тэжээгдэх ёстой вэ?
А. 12 В
Б. 36 В
В. 220 В
68. Аврах олсыг хоёр удаа татах нь юу гэсэн утгатай вэ?
А. Олсыг сулруул
Б. Хэвийн байна
В. Олсыг татаарай
Г. Аюулгүй
69. Галын аюул бүхий ажил хийгдсэн нарядуудыг хадгалах хугацаа нь наряд олгогдсон өдрөөс эхлэн хэдий хугацаанд хадгалах вэ?
А. 30 хоног
Б. 6 сар
В. 1 жил
Г. 185 хоног
70. Нарядыг хэдэн удаа сунгаж болох вэ?
А. Нарядыг сунгадаггүй.
Б. 2 удаа
В. 1 удаа
Г. 3 удаа
71. Үйлдвэрийн хүчтэй шуугиантай нөхцөлд ажиллах шуугианы түвшингийн хэмжээ 20 дБ-аас их байвал ажилтныг хэдий хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулах вэ?
А. 6 сард
Б. 12 сард
В. 24 сард
Г. 36 сард
72. Өндөрийн бүсийг хэдий хугацаанд хэдэн кг ачаагаар туршиж баталгаажуулах ёстой вэ?
А. Жилд нэг удаа 225 кг
Б. 24 сард 1 удаа 225 кг
В. Сард нэг удаа 225 кг
Г. 6 сард 1 удаа 225кг
73. Халуун гадаргуутай харьцах ажлын (цахилгаан станцын зуух ба турбин цех,) байранд ажилладаг ажилтныг хэдий хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулах вэ?

- А. 6 сард
- Б. 12 сард
- В. 24 сард
- Г. 36 сард

74. Дор дурдсан ажлуудын аль нь тусгай ажилд хамаарах вэ?

- А. Зуух даралтат саванд үйлчлэх
- Б. Цахилгаан ба зүлгэх багаж хэрэгслээр ажиллах
- В. Оосорлох
- Г. Дээрхи бүгд

75. Өндөрт шат барих, буулгах үед түүнээс хэдэн м-ээс бага зайд байгаа цахилгаан дамжуулах шугамын гүйдлийг тасалж газардуулах буюу утасных нь гадуур бүрхүүл хийх, эсвэл буулгаж зайлуулах хэрэгтэй вэ?

- А. 8 метр
- Б. 5 метр
- В. 3 метр
- Г. 6 метр

76. Албадлагын агааржуулалтыг зөөврийн салхилуур буюу компрессороор хийхдээ газар доорхи байгууламж буюу нөөцлөх савны агаар нь хэдэн минутанд бүрэн хэмжээгээр солигдож байхаар сонгож авах хэрэгтэй вэ?

- А. 10-15 минутад
- Б. 15-20 минутад
- В. 5-10 минутад
- Г. 8-15 минутад

77. Газар доорхи байгууламж буюу нөөцлөх саванд усны төвшин шалнаас дээш хэдэн мм-ээс дээш байхад ажил гүйцэтгэхийг хориглох вэ?

- А. 180 мм-ээс
- Б. 165мм-ээс
- В. 150 мм-ээс
- Г. 200 мм-ээс

78. Ээлжинд ажиллагсад нь ажил эхлэхээс хэдэн минутын өмнө ажлын байранд ирэх вэ?

- А. 1 цаг
- Б. 15 минут
- В. 30 минут
- Г. Заалт байхгүй.

79. Ээлжийн ажиллагсад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажилдаа гарах боломжгүй болсон тохиолдолд хэсгийн удирдлагагад ямар хугацаанд мэдэгдэх вэ?

- А. 8 цагийн өмнө
- Б. Ажил хүлээлгэн өгөхөөс өмнө
- В. 4 цагийн өмнө
- Г. 1 цагийн өмнө

80. Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээг юунд тусгах вэ?

- А. Хөдөлмөрийн гэрээ
- Б. дотоод журам нь
- В. Хөдөлмөрийн Хууль
- Г. Хамтын гэрээ

81. Хөдөлмөрийн дотоод журманд зааснаар сахилгын шийтгэл ногдуулсанаас хойш ямар хугацаа өнгөрвөл уг ажилтныг сахилгын шийтгэлгүйд тооцох вэ?

- А. 3 сар
- Б. 6 сар
- В. 1 жил
- Г. 1 сар

82. Ажил олгогч нь ажилтнаас ажил үүргээ биелүүлэхийг шаардаж болох уу?

- А. Хууль зөрчсөн албадлагын шинж чанартай үйлдэл тул хуулиар хориглосон
- Б. Ажилтан гэрээ байгуулсан учир сайн дураар ажиллах эрхтэй.
- В. Болохгүй
- Г. Болно

83. Дотоод журамд зааснаар "Ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан бол сарын болон жилийн үр дүнгийн шагналт цалин олгохгүй."

- А. Зөв
- Б. Буруу
- В. Заалт байхгүй

84. Ажилтан санал хүсэлт, гомдлоо захиргаанд ямар хэлбэрээр тавьж шийдвэрлүүлэх вэ?

- А. Аман болон бичгээр
- Б. Заавал бичгээр

86. Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг ямар ажилтантай байгуулах вэ?

- А. Бүх ажилтантай
- Б. Зөвхөн эд хөрөнгө хариуцах ажилтантай